



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/126

Булган сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.10, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 448 дугаар тогтоолын 1.16 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндсэн байгууллага аж ахуй нэгж нь Улаанбаатар хотод байрладаг боловч салбар нэгж нь Булган аймагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллагуудыг аймгийн үндсэн татвар төлөгчөөр бүртгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Батцогт (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Гишүүд Г.Давааням (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Б.Одхүү (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

А.Гантөмөр (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Ж.Ганболд (аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

Ү.Бямбасүрэн (аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

Ц.Бүрэнтуяа (Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга)

Б.Энх-Амгалан (аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга)

Сумын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Д.Лхагвасүрэн (аймгийн Татварын хэлтсийн дарга)

2. Ажлын хэсгийн төлөвлөгөөг гарган, гүйцэтгэсэн ажлын тайланг дараа жилийн 2 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргад танилцуулж байхыг ажлын хэсгийн дарга (Д.Батцогт)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Булган Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010242